

Tax reform is becoming effective soon

Contacts:

Michael Ahern
Partner & TLS Leader
michael.ahern@pwc.com

Tsendmaa Choijamts
Executive Director, Tax and Legal Services
tsendmaa.choijamts@pwc.com

Maryna Tarnavska
Senior Manager, Tax and Legal Services
tarnavska.maryna@pwc.com

Munkhjargal Ragchaakhuu
Senior Legal Consultant
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

PwC Tax TMZ LLC
Central Tower 6th floor
Suite 603, Ulaanbaatar
14200, Mongolia
Tel : + 976 70009089
Fax : +976 11 322068
www.pwc.com/mn

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2019 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC. All rights reserved. In this document, "PwC" refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.



The Parliament of Mongolia passed the revisions to the General Tax Law (GT Law), the Corporate Income Tax (CIT) Law, the Value Added Tax (VAT) Law and Personal Income Tax (PIT) Law on 22 March 2019. The revision of the tax laws will be effective starting from 1 January 2020.

There are several generic clauses in the revised tax laws and hence more clarification and guidelines are needed to be implemented for complied with the new changes. A number of new regulations are expected to be approved by the state authorities for implementation of the revised laws.

In brief, the revision of the tax laws changed the previous rules, and additionally introduced several new regulations and concepts as follows:

- General Anti Avoidance (GAAR) and Transfer Pricing (TP) rules
- Regulation on exchange of information in tax matters with foreign tax authorities
- Changes in the tax dispute process
- Tax fines and penalty
- VAT deduction rules
- Changed definition of a resident and non-resident taxpayers
- Detailed regulation on a permanent establishment (PE)
- Changes on income recognition for tax purposes
- Changes on rules for deduction of expenses for CIT purposes
- Change on a tax loss carryforward
- Tax credit for taxes paid in foreign countries
- Controlled Foreign Company (CFC) rules.

Please refer to the next pages for more details.



TAX ALERT

1. The main changes in the GT Law and the Infringement Law

Description	Changes
Statutory limitation period	Statutory limitation period for a tax inspection is reduced to 4 years from 5 years. Previously a statutory limitation period covered only a tax reassessment, fines and penalties. In addition, the statutory limitation under the new GT Law covers utilisation of a tax credit, tax loss carryforward and validation of the VAT assessment.
Anti avoidance rule	<p>General anti avoidance rule (GAAR) was introduced in the new GT Law. The risk management committee of the tax authorities will be in charge for implementing GAAR rules and will have a right to reassess taxes (a reassessment should cover the previous 4 years).</p> <p><i>Taxpayers should pay attention to related party transactions since the tax authorities introduced a new procedure for countering tax avoidance.</i></p>
The exchange of information in tax matters	The tax authorities will implement the exchange of information in tax matters . It is expected that the tax authorities will have an access to financial and ownership information of taxpayers.
Related party definition	The new unified definition of related parties was introduced, which is referable in all tax relations.
Comprehensive TP rules	<p>Comprehensive TP rules introduced to align with the OECD requirements. The qualifying entities would be required to report the annual TP report, local file, master file, country by country reporting. The detailed guidance on the TP reporting is expected to be issued.</p> <p><i>There will be a substantial penalty imposed for not reporting the above-mentioned TP documentation.</i></p>
Penalty on non-submission of TP reports	<p>In case of non-submission of TP reports, the following penalties will apply:</p> <ul style="list-style-type: none"> - For an annual TP report, a penalty is 2% from the total amount of related party transactions - For a local file and master file, a penalty is 3% from the total amount of related party transactions - For a country by country reporting, a penalty is 4% from the total amount of related party transactions.
Revision request from the tax authorities	The tax authorities will deliver a notice to taxpayers to revise a tax return if there is a discrepancy identified during a desk review of tax returns. A taxpayer is obliged to correct a tax return or to send an explanation to the tax authorities within 3 days upon receiving a notification. If a taxpayer does not act within 3 days or if the tax authorities view that the tax payer's explanation is groundless, this can be considered as a basis for initiating a tax inspection.
Tax payment deadline extension	The tax authorities may extend a tax payment deadline for up to 1 year based on a written request of a taxpayer, who is affected by several circumstances stated under the law (natural disasters, discontinued operation, medical conditions or loss incurred for three consecutive years), and although the extension period can be prolonged, totally it cannot exceed 2 years (currently the extension of tax payment deadline is up to 60 days).
Binding tax ruling	The tax authorities can issue a guidance/recommendation for the implementation of tax laws unbiddenly or upon a taxpayer's request . The guidance/recommendations will be placed on an open data source, unless it relates to the secret information of a taxpayer, the state, or a third party. If a request for recommendation relates to an investment agreement, a product sharing agreement, or TP reports, etc., the tax authorities have a right to reject such request.



1. The main changes in the GT Law and the Infringement Law (continued)

Description	Changes
<p>New definition of the ultimate beneficial owner (UBO)</p>	<p>The UBO is defined as “persons who directly own 30% or more of the shares, participation or voting rights of a legal entity holding a mining/petroleum license, a land use (or possess) right (Right); or indirectly owns, or implements voting rights, or has a right to receive dividends representatively through legal entities with a chain of ownership at one or more levels”. If the UBO changed, a taxpayer shall notify the tax authorities within 30 days. If the shares of the Right holder itself or its UBOs are traded in a local or an international stock exchange, the Right holder notifies on such changes by 20th July and 20th February of the following year respectively.</p>
<p>Tax authorities will collect taxpayers’ information from variety of sources to determine liabilities</p>	<p>Various state authorities and private organisations are obliged to provide taxpayers’ information to the tax authorities periodically or upon request, namely:</p> <ul style="list-style-type: none"> - State authorities, including treasury, customs, police, state registration authorities etc. - Mongolian stock exchange - Mineral Resources Authority - Notaries - Land authorities /respective Governor’s office/ - Commercial banks and non-banking institutions etc.
<p>Penalties for tax violation</p>	<p>Depending on types of the tax violations, the different law (either GT Law or Infringement Law) will apply for imposing penalties:</p> <ul style="list-style-type: none"> - Penalties in the GT Law will be applied for acts or omissions related to i) reduced tax payables, ii) failure to withhold taxes, iii) unfulfilled VAT obligations. - The amount of penalties was increased up to 50% of the re-assessed tax in addition to late payment penalties and compensation of the re-assessed taxes. - A concept of a repeated breach was introduced. In case of the repeated breaches, the penalty is 50% of the re-assessed tax is imposed in addition to all penalties and the re-assessed tax amount. - Penalties in the Infringement Law will be applied for acts or omissions, which can be immediately identified by inspectors without conducting inspections such as failure to submit tax reports or to pay taxes within the deadline, failure to register the necessary information within the deadline specified by laws, etc. - The amount of the late payment penalty will be increased by 20%.
<p>Mandate on a tax debt collection is broadened.</p>	<p>Tax authorities became solely responsible for collection and enforcement of a tax debt and the General Agency for Court Decision Enforcement will not be more involved in enforcement of court decisions regarding a tax debt.</p>
<p>A concept of a transferee tax liability</p>	<p>A concept of a transferee liability was introduced, which imposes a tax liability on a person other than a taxpayer who is actually liable for tax. The following event will trigger a transferee liability:</p> <ul style="list-style-type: none"> - A party received assets of a taxpayer free of charge or at the price lower than market within a year after a tax debt had been created - A taxpayer with a delinquent tax debt wrote off accounts receivable from any party. <p>The above liability is limited to a value of the asset transferred.</p>



TAX ALERT

2. The main changes in the CIT Law

Description	Changes
<p>Criteria for a foreign legal entity to become a Mongolian tax resident</p>	<p>A resident taxpayer is:</p> <ul style="list-style-type: none"> - An entity incorporated under Mongolian law - An entity, which effective place of management is located in Mongolia. <p>If a foreign legal entity satisfies three or more criteria specified below, then such entity can be treated as a Mongolian tax resident, namely:</p> <ul style="list-style-type: none"> - If more than 50% of the shareholders or shareholders who are exercising their shareholding rights and responsibilities through representatives directly and indirectly, are residing in Mongolia - If in the past consecutive four years prior to the respective tax year, more than 50% of the total Shareholder's meeting held in Mongolia - If the company's accounting and financial documents are kept in Mongolia - Not less than 25% of the board members, or those who are exercising board member's rights and responsibilities through their representatives directly and indirectly, are residing in Mongolia - Not less than 60% of the entity's sales revenue are earned in Mongolia, or sourced from Mongolia.
<p>New taxation rules on income earned by a non-resident taxpayer</p>	<ul style="list-style-type: none"> - The definition of “income sourced from Mongolia” introduced and includes, among others, income from a sale, a lease, a transfer of an asset (or a right to it) in its possession, ownership and use etc. - In contrast to current rules, whereby only a Mongolian resident taxpayer may perform as a withholding tax agent, under the new law a non-resident should be responsible for reporting and paying taxes on a self-assessment basis in absence of a withholding agent.
<p>New rules on tax loss carryforward</p>	<p>Tax losses can be carried forward up to 4 years for all taxpayers, irrespective of industry and restricted to 50% of taxable income.</p> <div style="border: 1px dashed orange; padding: 5px; margin-top: 10px;"> <p><i>The new loss carryforward rule is not applicable for losses incurred prior to 1 January 2020.</i></p> </div>
<p>General requirements for deductible expenses</p>	<p>General requirement for deductible expenses includes the following criteria that need to be satisfied simultaneously, namely:</p> <ul style="list-style-type: none"> - Expenses relevant to a reporting period - Expenses incurred for earning taxable income - Expenses actually incurred and supported by proper accounting documents - For some expenses listed in the law (e.g. purchases from resident taxpayers, purchase of immovable assets), there should be a valid VAT slip. For imported goods - supporting documents for taxes paid at customs. <p>In addition, there are certain limitations for specific expenses to be deductible:</p> <ul style="list-style-type: none"> - Expenses, from which taxes should be withheld, can be deducted only when relevant taxes are withheld and reported - For representative expenses, a 5% limit is applied (calculated from total salary expenses) - For repair and maintenance expenses, expenses for spare parts shall be included.
<p>New rules on the deduction of interest expenses</p>	<p>In addition to the current thin capitalization rule, which establish a 3 to 1 debt to equity ratio, limiting the deducting of interest for CIT purposes, a new restriction is introduced for interest deduction on related party loans. The deductible interest expense is restricted to 30% of EBITDA for a respective year.</p>



2. The main changes in the CIT Law (continued)

Description	Changes
Rules on PEs	<p>A PE definition is extended, which is in line with the international tax rules. The following concepts introduced in the new CIT law:</p> <ul style="list-style-type: none"> - a Construction PE should be constituted if a foreign entity is carrying activities for 90 days and more in Mongolia - a Service PE should be constituted if a foreign entity is providing services through employees or other personnel that present in Mongolia for 183 days and more within 12 consecutive months - an Agency PE should be constituted if an agent “habitually plays the principal role leading to the conclusion of contracts that are routinely concluded without material modification by the enterprise”. <p>The detailed PE guidance, including registration and tax reporting aspects, is expected to be issued by the tax authorities.</p>
Depreciation	<p>Tax depreciation rules were updated as follows:</p> <ul style="list-style-type: none"> - Tax depreciation term for buildings is decreased to 25 years from 40 years (this change will not apply to entities holding mining and petroleum licenses) - Depreciation term for computers and their accessories is decreased to 2 years from 3 years - Special depreciation rules for lease assets. <p>Depreciation of newly acquired assets should start from the 1st day of the month, following acquisition.</p>
CFC rules	<p>The CFC rules are introduced:</p> <ul style="list-style-type: none"> - A CFC shall be treated as a Mongolian tax resident - These rules shall not apply to a CFC that is established for IPO purposes - If a CFC conducts activities in the offshore zones identified in the Mongolian laws, special rules will apply.
Main changes in tax rates	<ul style="list-style-type: none"> - 25% tax bracket threshold is increased to MNT 6 billion - Entities with revenue of up to MNT 300 million will submit CIT returns on a semi-annual basis and will be taxed at 1% (not applicable to entities operating in mining, petroleum, alcoholic beverage and tobacco industries) - 5% tax will apply on interest income of an investor who purchased debt instruments of a local entity (not holding mineral resources, oil exploration and mining special licenses), traded in local and international stock markets.
Tax credits	<ul style="list-style-type: none"> - 90% tax credit for taxpayers, which revenue is less than MNT 1.5 billion and operate in industries other than mining, petroleum, alcoholic beverage and tobacco industries - Provided certain conditions are met, taxes paid in foreign countries, can be credited against taxes payable in Mongolia
Tax reporting/filing	<p>Depending on prior year taxable income:</p> <ul style="list-style-type: none"> - Taxpayers with taxable income of more than MNT 6 billion shall file a CIT return on a quarterly basis - Taxpayers with taxable income of less than 6 billion shall file a CIT return twice a year.
Ring fencing rules	<p>Mining companies will report income, expenses, tax loss carryforward for each license separately.</p>



TAX ALERT

3. The main changes in the PIT Law

Description	Changes
Rules on determining a tax residency	<p>A resident taxpayer is an individual who meets one of the following criteria:</p> <ul style="list-style-type: none"> - Residing in Mongolia for more than 183 days in consecutive 12 months period - 50% or more of the total assessable income earned in Mongolia or from the Mongolian sourced income.
Foreign tax deduction	<p>Provided certain conditions are met, taxes paid in foreign countries, which have agreements on the exchange of information in tax matters with Mongolia, can be deducted by tax residents of Mongolia against tax payable in the reporting period.</p>
Main changes in taxing an employee allowances	<p>Meal and transportation allowance is classified as direct income, taxed after deducting a social insurance contribution.</p> <p>Voluntary, health, accidental and professional liability insurance contributions paid by an employer in relation to employment are not more subject to a PIT.</p>
Individual's income portion in cross border contracts	<p>Individuals' income shall be specified in contracts concluded between Mongolian and foreign entities. A portion of income, allocated to an individual, shall be taxed with a PIT if an individual comes to work in Mongolia. If income is not specified in a contract, expenses incurred in relation to individuals' working in Mongolia shall be considered as taxable income, subject to a PIT.</p>

4. The main changes in the VAT Law

Deductibility of input VAT for fixed assets	<p>Input VAT paid on purchases/importation of fixed assets will be recovered within the following periods under the straight-line method:</p> <ul style="list-style-type: none"> - For building and construction -10 years - For equipment (including exploration expense) - 5 years - Others assets – directly recoverable.
VAT on the loan interest	<p>Under the current law, the loan interest income of non-banking lenders is not clearly regulated. Starting from January 2020 all types of interest income are exempt from a VAT.</p>

Татварын шинэчилсэн хуулиуд удахгүй хэрэгжиж эхэлнэ

Холбогдох хаяг:

Майк Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Марина Тарнавска

Ахлах Менежер, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tarnavska.maryna@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Прайсуотерхаускуперс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол Улс
Утас: + 976 70009089
Факс: +976 11 322068
www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдгээс гарах аливаа харнуцлагыг бид харинуцахгүй болно.

© 2019 "Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited -ийн гишүүн байгууллага болох Прайсуотерхаускуперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.



Монгол Улсын Их Хурал шинэчлэн найруулсан Татварын ерөнхий хууль (ТЕХ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын тухай хууль, Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын тухай хуулиуд болон Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-ын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 3-р сарын 22 -ны өдөр баталлаа. Хуулийн өөрчлөлтүүд нь 2020 оны 1 сарын 1 –ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Шинэчлэн баталсан хуулиудад зарим ерөнхий заалтууд байгаа бөгөөд эдгээр шинэ өөрчлөлтүүдийг хэрэгжүүлж, дагаж мөрдөхөд нэмэлт тодруулга, журмууд шаардлагатай бөгөөд холбогдох төрийн байгууллагуудаас шинэчлэгдсэн хуулиудыг дагаж мөрдөх журмууд батлагдаж гарахаар хүлээгдэж байна.

Татварын хуулийн өөрчлөлтүүдээр өмнөх зохицуулалтуудыг шинэчилж, дор дурдсан шинэ ойлголт, зохицуулалтууд шинээр нэмэгдсэн:

- Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм болон Үнэ шилжилтийн дүрэм
- Гадаад улсын татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам
- Татварын маргаан шийдвэрлэх ажиллагааны өөрчлөлт
- Татварын торгууль, алданги
- НӨАТ –ын хасалт хийх зохицуулалт
- Оршин суугч болон оршин суугч бус татвар төлөгчийн шинэчлэгдсэн тодорхойлолт
- Төлөөний газар (ТГ) -ын талаарх нарийн зохицуулалтууд
- Татварын зорилгоор орлого хүлээн зөвшөөрөх зохицуулалтын өөрчлөлт
- ААНОАТ –ын хасагдах зардлын өөрчлөлт
- Алдагдал шилжүүлэн тооцох зохицуулалтын өөрчлөлт
- Гадаад улсад төлсөн албан татварыг хасах зохицуулалт
- Удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгжийн зохицуулалт

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн хуудаснуудаас харна уу.

1. ТЕХ болон Зөрчлийн тухай хуулийн гол өөрчлөлтүүд

Товч тайлбар

Өөрчлөлт

Хөөн хэлэлцэх хугацаа

Татварын хөөн хэлэлцэх хугацаа 5 жилээс **4 жил** болж өөрчлөгдсөн. Хөөн хэлэлцэх хугацаа татварын нөхөн ногдуулалт, татварын алданги, торгуулийг хамардаг байсан бол шинэ ТЕХ-д татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх мөн НӨАТ –ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулахад мөн хамаарахаар өөрчлөгдсөн.

Татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм



Шинэ ТЕХ –д **Татвараас Зайлсхийхийн Эсрэг Ерөнхий Дүрэм** (ТЗЭЕД) шинээр тусгагдсан. Татварын албаны эрсдэлийн удирдлагын хороо ТЗЭЕД-ийг хэрэгжүүлэх, татварыг нөхөн ногдуулах (өмнөх 4 жилийг хамарна) үйл ажиллагааг хариуцаж ажиллахаар зохицуулагдсан байна.

Татвараас зайлсхийхтэй тэмцэх шинэ зохицуулалт үйлчилж эхлэх тул татвар төлөгчид харилцан хамааралтай этгээдүүдтэй хийгдэх ажил гүйлгээндээ анхаарал хандуулах шаардлагатай.

Татварын зорилгоор мэдээлэл солилцох журам

Татварын албад **татварын зорилгоор мэдээлэл солилцох ажлыг** хэрэгжүүлж эхэлж байгаа бөгөөд тэд татвар төлөгчийн санхүүгийн болон эзэмшигчийн мэдээллийг мэдэх боломжтой болох юм.

Харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолт

Харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолт шинэчлэгдсэн бөгөөд энэ нь бүх төрлийн татварын харилцаанд ашиглагдана.

Үнэ шилжилтийн цогц зохицуулалт



ЭЗХАБ –ын ҮШ –ийн зохицуулалтад нийцсэн **ҮШ-ийн цогц** зохицуулалтыг шинээр баталсан. Шаардлагатай татвар төлөгчид ҮШ-ийн жилийн тайлан, дотоод ҮШ –ийн тайлан, ерөнхий ҮШ-ийн тайлан болон улс бүрээр тайланг тайлагнах шаардлагатай. ҮШ-ийн тайлан бэлтгэх нарийвчилсан аргачлал батлагдахаар хүлээгдэж байна.

Дээр дурдсан ҮШ –ийн тайланг тайлангнаагүй тохиолдолд их хэмжээний торгууль ногдуулна.

ҮШ –ийн тайлангуудыг гаргаагүй тохиолдолд ногдуулах торгууль

ҮШ тайлангуудыг гаргаагүй бол доорх торгуулийг ногдуулна:

- ҮШ ажил гүйлгээний жилийн тайлангийн хувьд **харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 2 хувь**
- ерөнхий үнэ шилжилтийн тайлан, эсхүл дотоод үнэ шилжилтийн тайлангийн хувьд **харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 3 хувиар торгоно**
- улс бүрээр тайлангийн хувьд **харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 4 хувиар торгоно.**

Татварын албанаас тавих тайлангийн зөрүү залруулах шаардлага

Татварын алба татварын тайланг хянаж мэдээллийн зөрүү илэрвэл илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор мэдээллийн зөрүүг залруулах **шаардлагыг татвар төлөгчид хүргүүлнэ**. Татвар төлөгч шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын **3 өдөрт** багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах, эсхүл шаардлагыг үндэслэлгүй гэж үзсэн тайлбараа хүргүүлэх үүрэгтэй. Хэрэв татвар төлөгч 3 хоногийн дотор шаардлагатай арга хэмжээг аваагүй, эсхүл татварын албан татвар төлөгчийн тайлбарыг үндэслэлгүй гэж үзвэл энэ нь **татварын хяналт шалгалт хийх үндэслэл болох** боломжтой.

Татвар төлөх хугацааны сунгалт

Татварын алба нь хуульд заасан тодорхой нөхцөлүүдийн улмаас (байгалийн гамшиг, үйл ажиллагаагаа зогсоосон, эрүүл мэндийн шалтгаан, мөн дараалсан 3 жилийн хугацаанд алдагдалтай ажилласан) татвар төлөх боломжгүй болсон татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн **татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгах** бөгөөд энэхүү хугацааг ахин сунгах боломжтой боловч нийт хугацаа **2 жилээс хэтрэхгүй** байхаар зохицуулсан (одоогийн хуулиар татвар төлөх хугацааг 60 хүртэлх хоногоор сунгах боломжтой) .

1. ТЕХ болон Зөрчлийн тухай хуулийн гол өөрчлөлтүүд (үргэлжлэл)

Товч тайлбар	Өөрчлөлт
Татварын хууль тогтоомж хэрэгжүүлэх зөвлөмж	Татварын алба татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмжийг татвар төлөгчийн хүсэлтэнд үндэслэн эсхүл татварын алба өөрөө гаргах боломжтой . Татварын хуулийг хэрэгжүүлэх зөвлөмж нь татвар төлөгчийн, төрийн, эсхүл гуравдагч этгээдийн нууц мэдээлэл агуулаагүй бол олон нийтэд нээлттэй цахим санд байршина. Хууль тогтоомж хэрэгжүүлэх зөвлөмж авах хүсэлт нь хөрөнгө оруулалтын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, ҮШ тайлантай хамааралтай зэрэг тохиолдлуудад татварын алба хүсэлтийг хүлээж авахаас татгалзаж болно.
Эцсийн эзэмшигчийн шинэ тодорхойлолт	Эцсийн эзэмшигч гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг , саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг хэлнэ. Татвар төлөгч нь эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд 30 хоногийн дотор (хаалттай аж ахуй нэгжүүд), эсхүл жил бүрийн 7 сарын 10 болон 2 сарын 10 дотор (нээлттэй хувьцаат компаниуд) бүртгүүлж тайлагнах үүрэгтэй. Хууль зөрчсөн тохиолдолд лиценз, газрын эрхийг цуцлах шийтгэлтэй.
Татварын алба татвар төлөгчийн мэдээллийг хөндлөнгийн байгууллагаас авч татварын ногдлыг тодорхойлоход ашиглаж болно	Дараах төрийн болон хувийн байгууллагууд татварын албанд тогтсон хугацаанд эсхүл татварын албанаас шаардах үед мэдээлэл гаргаж өгөх үүрэгтэй: <ul style="list-style-type: none"> - Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллага, гаалийн байгууллага, цагдаагийн байгууллага, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллага гэх зэрэг төрийн байгууллагууд - Монголын хөрөнгийн бирж - Нотариат - Газрын алба - Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага гэх мэт.
Татварын хууль зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлага	Татварын зөрчлийн төрлөөс хамаарч ТЕХ эсхүл Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ: <ul style="list-style-type: none"> - ТЕХ –д заасан торгууль нь дараах тохиолдлуудад хамаарна: i) Төлөх татварын хэмжээг бууруулсан, ii) суутгаж авах татварыг суутгаагүй, iii) НӨАТ –ын тухай хууль зөрчсөн - Нөхөн төлүүлэх татвар, төлөөгүй татварг ногдох алдангийн хэмжээ нь нөхөн төлүүлэх татварын 50 хувь хүртэл нэмэгдсэн - Зөрчлийг давтан үйлдсэн талаарх зохицуулалтыг шинээр танилцуулсан. Давтан үйлдсэн зөрчилд ногдох нөхөн төлбөл зохих татвар түүнд ногдох торгуулийн дүн дээр тухайн нөхөн төлүүлэх татварын дүнгийн 50 хувиар нэмж торгоно. - Зөрчлийн тухай хуульд заасан арга хэмжээ нь татварын тайланг хугацаанд нь гаргаагүй, татварыг хугацаанд нь төлөөгүй, шаардлагатай мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлээгүй зэрэг зөрчил үйлдсэн нь ил тодорхой, зөрчлийг нотлох шаардлагагүй зөрчил, эс үйлдэхүйд хамаарна. - Татварыг хугацаанд нь төлөөгүйд ногдуулах торгуулийн хэмжээ 20 хувиар нэмэгдсэн.
Татварын өр хураах эрх мэдэл нэмэгдсэн	Татварын өрийг хураах болон түүний албадлагын арга хэмжээг татварын алба дангаар хэрэгжүүлэхээр өөрчлөгдсөн бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар татварын өртэй холбогдох шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэхэд оролцохгүй болсон.
Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд	Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн талаарх ойлголтыг шинээр танилцуулсан ба дараах тохиолдолд татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд өртэй татвар төлөгчийн татварын өрийг барагдуулахаар зохицуулсан байна: <ul style="list-style-type: none"> - татварын өр үүссэн хуулийн хугацаанаас нэг жилийн өмнөх өдрөөс хойш хугацаанд тухайн өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр шилжүүлсэн хоёрдогч тал - Хоёрдогч талаас авах авлагаа хүчингүй болгосон Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн шилжүүлж авсан хөрөнгө, хүчингүй болгосон авлагын хэмжээгээр татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн төлөх татварын хэмжээ хязгаарлагдана.

2. ААНОАТ тухай хуулийн гол өөрчлөлтүүд

Товч тайлбар	Өөрчлөлт
<p>Оршин суугч болон оршин суугч бус албан татвар төлөгч</p>	<p>Оршин суугч татвар төлөгч :</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуй нэгж - Удирдах байгууллага нь Монгол улсад байрладаг гадаадын аж ахуй нэгж <p>Дараах шалгууруудын 3 ба түүнээс дээш нөхцөлийг хангасан гадаадын аж ахуй нэгж Монгол улсын оршин суугч татвар төлөгч байна:</p> <ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигч, эсхүл өөрийн төлөөллөөрөө дамжуулан хувьцаа эзэмшигчийн эрх, үүргээ шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг хувьцаа эзэмшигчдийн 50-иас дээш хувь нь Монгол Улсад оршин суудаг; - Тухайн татварын жилийн өмнөх дараалсан дөрвөн жилд хувьцаа эзэмшигчдийн хурлын нийт тооны 50-иас дээш хувь нь Монгол Улсад зохион байгуулагдсан; - Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн баримтыг Монгол Улсад хадгадаг; - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эсхүл өөрийн төлөөллөөрөө дамжуулан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүргээ шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг этгээдийн 25-аас доошгүй хувь нь Монгол Улсад оршин суудаг; - Нийт борлуулалтын орлогын 60-аас доошгүй хувийг Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олдог
<p>Оршин суугч татвар төлөгчийн олсон орлогыг татваржуулах шинэ зохицуулалт</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол улсаас эх үүсвэртэй орлогын тодорхойлолт шинээр нэмэгдсэн бөгөөд үүнд борлуулалтын орлого, Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгчийн эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө (эзэмших эрх) -ийг борлуулсан шилжүүлсний орлого гэх мэт орлогууд хамаарна - Одоогийн зохицуулалтаар Монгол улсын оршин суугч татвар төлөгч суутган төлөгчийн үүрэг гүйцэтгэдэг одоогийн зохицуулалтаас гадна шинэ хуулийн дагуу суутган төлөгч байхгүй тохиолдолд оршин суугч бус этгээд өөрөө татвараа төлж тайлагнах үүрэгтэй байхаар зохицуулагдсан
<p>Алдагдал шилжүүлэн тооцох</p>	<p>Алдагдал шилжүүлэн тооцох хугацаа нь салбараас үл хамааран 4 жил болж өөрчлөгдсөн бөгөөд тайлант үеийн албан татвар ногдуулах орлогын 50 хувиар хязгаарлан хасч тооцно.</p> <div style="border: 1px dashed orange; padding: 5px; margin-top: 10px;"> <p><i>Алдагдал шилжүүлэн тооцох шинэ аргачлал нь 2020 оны 1 дүгээр сарын 1 -ээс өмнө хэрэгжсэн алдагдалд хамаарахгүй</i></p> </div>
<p>Хасагдах зардалд тавигдах ерөнхий шаардлагууд</p>	<p>Хасагдах зардалд тавигдах ерөнхий шаардлагуудад доорх нөхцөлүүд хамаарагдах бөгөөд нэгэн зэрэг хангасан байх шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн татварын тайлант хугацаанд хамаарсан байх - Албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх - Зардал бодитой гарсан бөгөөд шаардлагатай баримт бүртгэлээр баталгаажсан байх - Хуульд заасан зарим зардлуудын хувьд (оршин суугч этгээдээс авсан ажил үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт) НӨАТ –ын баримтаар баталгаажсан байх шаардлагатай. <p>Түүнчлэн зарим зардлуудын хувьд тодорхой хасагдах зардлын хязгаарлалтууд үйлчилнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Татвар суутгах орлого олгосон тохиолдолд татварыг суутган авч тайлагнасан тохиолдолд хасч тооцно - Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал нь тухайн жилийн цалингийн зардлын 5 хувиас хэтрэхгүй - Засварын зардалд сэлбэг хэрэгслийн зардлыг оруулж тооцно
<p>Албан татвар ногдох орлогоос хасаж тооцох хүүгийн зардал</p>	<p>ААНОАТ –ын зорилгоор хасагдах хүүгийн зардалд тавигдах хязгаарыг тодорхойлсон одоогийн өр төлбөр эзний өмчийн 1:3 нимгэн капиталжуулалтын зохицуулалт дээр нэмэгдэн харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний хасагдах хүүгийн зардлын хэмжээ нь тайлант хугацааны хүү, татвар, элэгдэл хорогдлын өмнөх ашгийн 30 хувиар хязгаарлагдана.</p>

2. ААНОАТ тухай хуулийн гол өөрчлөлтүүд (үргэлжлэл)

Товч тайлбар Өөрчлөлт

<p>ТГ –ын зохицуулалт</p>	<p>ТГ –ын тодорхойлолтууд олон улсын татварын зохицуулалтад нийцсэн байдлаар илүү дэлгэрэнгүй болж өөрчлөгдсөн. ААНОАТ –ын шинэ хуульд дараах ойлголтууд шинээр нэмэгдсэн:</p> <ul style="list-style-type: none"> - Гадаадын хуулийн этгээд Монгол улсад 90 болон түүнээс дээш хоног үйл ажиллагаа явуулсан бол Барилгын ТГ үүссэн гэж үзнэ - Гадаадын хуулийн этгээд өөрийн ажилтан эсхүл өөр бусад хөлсний ажилтнаар дамжуулан үргэлжилсэн 12 сарын хугацаанд 183 болон түүнээс дээш хоногийн хугацаанд Монгол улсад үйлчилгээ үзүүлсэн бол Үйлчилгээний ТГ үүссэн гэж үзнэ - Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгчийн гэрээний гол нөхцөлийг өөрчлөхгүйгээр гэрээ байгуулах удирдан зохион байгуулдаг, эсхүл биечлэн гэрээ байгуулдаг этгээдийг Агентийн ТГ үүссэн гэж үзнэ г.м <p>Татварын албанаас төлөөний газрыг бүртгэх, татвар төлөх тайлагнахтай холбоотой журмыг батлахаар хүлээгдэж байна.</p>
<p>Элэгдэл</p>	<p>Татварын зорилгоор элэгдэл тооцох зохицуулалт дараах байдлаар өөрчлөгдсөн:</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын элэгдэл 40 жилээс 25 жил болж буурсан (ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хамааралгүй) - Компьютер, дагалдах тоног төхөөрөмж, программ хангамжийн элэгдэл 3 жилээс 2 жил болж буурсан - Түрээсийн хөрөнгийн хувьд элэгдлийг хуульд заасны дагуу элэгдүүлнэ <p>Шинээр эзэмшсэн хөрөнгийн элэгдлийг дараагийн сарын эхний өдрөөс эхлэн тооцно (өмнөх хуулиар дараагийн улирлын эхний өдрөөс эхлэн тооцдог байсан)</p>
<p>Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсад хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж</p>	<p>Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсад хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж (ҮАУМУХГААН) -ийн талаарх зохицуулалт шинээр танилцуулагдсан:</p> <ul style="list-style-type: none"> - ҮАУМУХГААН нь Монгол улсын оршин суугч татвар төлөгч байна - Үнэт цаасны анхдагч зах зээлд хувьцаа, нэгж эрхээ нээлттэй арилжаалах зорилгоор байгуулагдсан бол ҮАУМУХГААН –д хамаарахгүй - Монгол улсын хуульд заасан оффшор бүсэд үйл ажиллагаа явуулсан, ҮАУМУХГААН –д тусгай зохицуулалт үйлчилнэ.
<p>Татварын хувь хэмжээний гол өөрчлөлтүүд</p>	<ul style="list-style-type: none"> - 25% -иар татвар ногдуулах жилийн орлогын босго 6 тэрбум болж өссөн - 300 сая болон түүнээс дооших жилийн татвар ногдох орлого олсон, уул уурхай согтууруулах ундаа тамхины үйлдвэрлэл, газрын тосны салбарын бус татвар төлөгчид 1% албан татвар ногдуулна - Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн (ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй) гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлогод 5 хувиар татвар ногдуулна.
<p>Татварын хөнгөлөлт</p>	<ul style="list-style-type: none"> - Жилийн татвар ногдох орлогын хэмжээ 1.5 тэрбумаас доош уул уурхай согтууруулах ундаа тамхины үйлдвэрлэл, газрын тосны салбарын бус татвар төлөгчдөд 90 хувийн татварын хөнгөлөлт - Тодорхой нөхцөлүүдийг хангасан тохиолдолд гадаад улсад төлсөн албан татварыг Монгол улсад төлбөл зохих албан татвараас хасч тооцно.
<p>Татварын тайлан гаргах</p>	<p>Өмнөх жилийн албан татвар ногдуулах орлогын дүнгээс хамаарч:</p> <ul style="list-style-type: none"> - 6 тэрбумаас дээш албан татвар ногдуулах орлоготой татвар төлөгч ААНОАТ тайланг улирал тутам тайлагнана - 6 тэрбумаас дээш албан татвар ногдуулах орлогтой татвар төлөгч ААНОАТ тайланг хагас жил тутам тайлагнана
<p>Тусгай зөвшөөрөл бүрээрх тайлагнал</p>	<p>Уул уурхайн компаниуд тусгай зөвшөөрөл бүрээр орлого, зардал, алдагдал шилжүүлэх тооцоог хийж тайлагнана.</p>

3. ХХОАТ тухай хуулийн гол өөрчлөлтүүд

Товч тайлбар	Өөрчлөлт
Оршин суугч татвар төлөгчийг тодорхойлох	<p>Оршин суугч татвар төлөгч нь доорх 2 нөхцөлүүдийн аль нэгийг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсад дараалсан 12 сарын туршид 183 болон түүнээс дээш хоног оршин суусан байх - Нийт татвар ногдох орлогын 50 болон түүнээс дээш хувь нь Монгол улсад, эсхүл Монгол улсаас эх үүсвэртэй орлого байх
Гадаад улсад төлсөн албан татварыг хасч тооцох	Монгол улстай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох гэрээтэй гадаад улсад төлсөн албан татварыг тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдолд Монгол улсад оршин суугч татвар төлөгчийн тухайн жилийн төлбөл зохих татвараас хасч тооцно.
Ажилтанд олгосон орлогод татвар ногдуулахтай холбоотой гол өөрчлөлтүүд	<p>Хоол болон унааны хөнгөлөлтийг нийгмийн даатгалын шимтгэлийг хасч тооцсоны дараа татвар ногдуулах шууд орлогын ангилалд оруулж өөрчилсөн.</p> <p>Хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор ажил олгогчийн төлсөн сайн дурын эрүүл мэнд, гэнэтийн осол болон мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамжид ХХОАТ ногдуулахгүй.</p>
Оршин суугч бус этгээдтэй байгуулсан гэрээнд заагдсан хувь хүний орлого	Монгол Улсад оршин суугч этгээд болон Монгол Улсад оршин суугч бус этгээд хооронд байгуулсан аж ахуйн үйл ажиллагааны гэрээнд тухайн оршин суугч бус этгээдийг төлөөлж ирж ажилласан хувь хүнд олгосон орлогыг талууд гэрээнд тусгасан байна. Тухайн хувь хүн Монгол улсад ирж ажилласан бол хувь хүнд ногдох орлогод ХХОАТ ногдуулна. Гэрээнд тодорхой тодорхой тусгагдаагүй тохиолдолд тухайн хувь хүний Монгол Улсад хүрэлцэн ирж ажиллахтай холбогдон гарсан зардлын дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

4. НӨАТ –ын тухай хуулийн гол өөрчлөлтүүд

Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн НӨАТ –ыг хасч тооцох	<p>Үндсэн хөрөнгө худалдан авах, импортлоход төлсөн НӨАТ нь доорх байдлаар хувь тэнцүүлэн хасагдуулах боломжтой болсон:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжид 10 жил - Тоног төхөөрөмжид 5 жил (хайгуулын үйл ажиллагааны зардлыг хамааруулан) - Бусад үндсэн хөрөнгөнд тухай бүрт
Хүүгийн орлогод ногдох НӨАТ	Одоогийн хуулиар, банк санхүүгийн байгууллагаас бусад байгууллагын зээлийн хүүгийн орлогод НӨАТ ногдуулах эсэхийг тодорхой зохицуулаагүй байдаг. НӨАТ –ын хуулийн шинэчилсэн найруулгаар бүх төрлийн хүүгийн орлогод НӨАТ ногдуулахгүй байхаар тодорхой зохицуулсан.